

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234730

**МОНГОЛ УЛСЫН БРАХМИ БИЧЭЭСИЙГ ТАЙЛЖ УНШСАН ХҮНИЙ
ТУХАЙ**

Англи хэлнээс орчуулсан Б.Беньямин

Монгол Хүйс Толгой болон Бугатын бичээсийг тайлж уншсан тухай ойлголтыг залруулах шаардлагатай хэмээн үзэж бид энэхүү товч мэдэгдлийг хүргэж байна.

Хүйс Толгой ба Бугатын хөшөөний бичээсийн бичсэн хэлний талаарх мэдлэг олон зуун жилийн өмнө үгүй болсон тул тус бичээсийг саяхан болтол хэн ч тайлж уншиж чадаагүй байсан юм. Харин 2000-аад оны үед Дийтэр Мауэ (Dieter Maue) гэдэг эпиграфч, Брахми бичгийн тэргүүлэх эрдэмтэн уг бичээсийг шинээр тайлан уншиж, түүнийг ямар хэлээр бичигдсэн тухай асуудалд нухацтайгаар хандах боломжийг анх удаа дэвшүүлэн гаргасан юм. Үүний дараа Франц түүхч Этьен де Ла Вайssiер (Étienne de La Vaissière) Александр Вовин (Alexander Vovin)-ыг Парист очиход нь урьж, Мауэгийн тайллыг үзүүлжээ. Вовин хэдийгээр уг бичээсийн бичигдсэн хэлийг Монгол хэл гэж тодорхойлсон ч баларч танигдахгүй болсон үг, хэлзүйн хэлбэр олон байсан учраас бүрэн гүйцэт тайлан унших боломжгүй байжээ. 2014 онд Дийтэр Мауэ (Герман), Александр Вовин (АНУ, тухайн үед Франц Улсад эрдэм шинжилгээний салбарт судалгааны удирдах ажилтай болсон байсан үе), Мэхмэт Өлmez (Mehmet Ölmez) (Турк), Этьен де Ла Вайssiер (Франц) нарын дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй, мөн хоёр 3D зургийн мэргэжилтний хамт шаардлагатай тоног төхөөрөмж бүхий олон улсын баг бүрдэж Монгол руу аялсан юм. Энэхүү аялал нь хөшөөний бичээсийг аль болох бүрэн бүтэн баримтжуулж авах зорилготой байв.

Тус олон улсын баг нь Хүйс Толгой 1 ба Бугатын Брахми бичгийг нарийвчлан судалж 3D зургуудыг буулгаж авсан бөгөөд харин тус судалгааны багийнхнаас үл хамаарах шалтгаанаар Хүйс Толгой 2 бичээсийг судалж, зурагжуулж авч чадаагүй юм. Судалгааны багийн Монголд хийсэн аяллын талаарх мэдээллийг Өлmez (2018)-ээс үзэж болно. Ингээд сайн судлан шинжилсний үндсэн дээр Дийтэр Мауэ өөрийн эпиграф тайллаа засварлан шинэчилж, Александр Вовин тус бичээсийг анх удаа хэл шинжлэлийн болон эх бичгийн бичээсийн талаас нь судалж зохих тайлбарыг хийжээ. Ингээд судалгааныхаа ажлын үр дүнг 2017 оны 8 дугаар сарын 31-нээс 9 дүгээр сарын 01-нд Унгар Улсын Щекесфехерваар (Székesfehérvár) хотод болсон 60 дахь удаагийн Олон Улсын Алтай судлалын эрдэм шинжилгээний хурал (PIAC) дээр танилцуулсан юм. Түүний дараа уг илтгэлээ өгүүлэл болгон бичиж эхний төсөл хувилбарыг нь интернет дээр байршуулсан байна (Maue & Ölmez 2017, Vovin 2017). Дэлхийд алдартай олон

Монголч эрдэмтдээс авсан санал сэтгэгдлийг тусган энэхүү судалгааныхаа үр дүнг *Journal Asiatique* сэтгүүлд хэвлүүлжээ (Ölmez 2018, Maue 2018, Vovin 2018, de La Vaissière 2018). Бугатын Брахми бичээсийн талаарх судалгааны багийн ажлын нийт үр дүн, ололт амжилтыг дараа онд нь *Journal Asiatique* сэтгүүлд хэвлүүлж олны хүртээл болгожээ (Ölmez 2019, Maue 2019, Vovin 2019a). Мөн үргэлжлүүлэн Брахми Бугат болон Хүйс толгой бичээсийн суурь хэлний авиа зүй, хэл зүйн болон үгсийн сангийн талаарх нарийвчилсан тайлбар танилцуулгыг болон Казакстан Улсад байх хоёр богино Хэрэнгэнтасын бичээсийн барагцаалсан орчуулгын хамтаар нийтлэн хэвлүүлжээ (Vovin 2019b).

2017 оны сүүлээр юм уу, 2018 оны эхээр Солонгод овогт Л.Хурцбаатар Александр Вовинд материалыа хуваалцана уу гэсэн хүсэлтийг тавьсан боловч Вовин түүний хүсэлтийг хүлээж аваагүй юм. Хурцбаатар бол Ордосоос (ӨМӨЗО) гаралтай Герман Улсын иргэн, одоогоор Көлн хотод зочид буудлын салбарт ажил эрхэлдэг, 2001 онд Тюбингэн хотод Чингис хааны шүтээн тахилгын тухай сэдвээр докторын зэргээ хамгаалж, герман хэлээр бичсэн докторын ажлаа япон Улсад хэвлүүлсэн хүн. Тэрээр судалгааны багийн гишүүдийн гаргасан эрдэм шинжилгээний нийтлэлийг хэвлэгдсэнээс хойш буюу 2019 оны 7 дугаар сард монгол бичгээр нэг ном гаргасан бөгөөд тус номдоо Хүйс Толгой I, II болон Брахми Бугатын тайллыг бүгдийг нь тайлсан гэж тунхаглан зарласан бөгөөд 2020 онд Хурцбаатар уг номоо бага сага нэмэн засаж кирилл үсгээр гаргажээ. Эртний бичиг тайлал, түүхэн хэл шинжлэлийн талаар урьд нь судалгаа шинжилгээний ажил хийж байгаагүй өөр ангид салбарын буюу угсаатан судлалын эрдэмтэн хүн Маэ болон Вовиний бүтээлийг үзэлгүйгээр уг бичээсийг бие даан тайлж уншиж чадсан эсэх нь үнэндээ магадлал багатай. Түүний өөрийнх нь бичсэнээр Хурцбаатар Маэгийн галиг дээр суурилан хэд хэдэн өөрчлөлт хийж өөрийн галигийг гаргасан нь том асуудал биш. Харин Вовины судалгааны ажлын тухай номдоо бичихдээ, нэг талаас “бичээсний агуулгыг бид хоёр адилгүй уншжээ” (Хурцбаатар 2020: 104) гэх боловч нөгөө талаас түүний уншлагыг үндэслэл муутай таамаглал, жинхэнэ уншлага биш, бас Вовин зүгээр л уг бичээсийн хэлийг монгол хэл мөн гэж анх таньсан хүн, Хурцбаатар өөрөө харин “бичээсийн агуулгыг бүрэн зөв уншиж, Хүйс толгойн бичээсийг үндэслэн хэл зүй, жич үг, үгийн бүтцийг анхлан судлан батал[сан] (...) хүн” (Өдрийн сонин 2021-03-30) гэж илэрхийлж байгаа нь их асуудалтай. Хүйс Толгойн II тайлал нь Б. Напилын 2005 оны зурган материал, дармал хуулбар хоёрт тулгуурласан бөгөөд Хэрэнгэнтас хоёр бичээсийг тусгайлан задлан шинжлээгүй байна. Энэхүү “дүн шинжилгээндээ” тэрээр уг бичээс нь Түрэгийн Анхны Хаант улсын хүрээнд бичигдсэн болон мөн түүний улмаас маш олон Түрэг үсэг орсон гэдгийг нь төдийлөн харгалзаж үзээгүй байгаа юм. Тус бичээсийг бүрэн дүүрэн судалж ойлгоход маш их ажил хийгдэх шаардлагатай байгаа хэдий ч цаг хугацаа уг ажилд энэ хүний бие даан оруулсан хувь нэмэр тун бага юм гэдгийг харуулах болно. Хамгийн чухал нь тэрээр эдгээр бичээсийг анх удаа тайлж уншсан, Вовины хийсэн уншлагыг муу, тоож анхаарах хэрэггүй гэж мэдэгдэж байгаа нь зүйд үл нийцэх үйлдэл юм.

Энэхүү үйл явдлаас үүдэн гарсан хамгийн сэтгэл гонсойлгом зүйл нь Монгол Улсын Засгийн газар Хурцбаатарт 2021 оны 8 дугаар сарын 05-ны өдөр Монгол

төрийн өндөр шагнал болох Алтан гадас одонг олгосон явдал юм. Хэдийгээр Бүгд Найрамдах Хятад Ард Улс Монгол судлалыг шахан хавчиж буй өнөө үед Өвөр Монголоос гаралтай эрдэмтний судалгааны ажлыг Монгол Улсын засгийн газар үнэлж төрийн өндөр шагнал олгох нь сайшаалтай үйлс боловч энэ удаа буруу хүнээ сонгосон гэж бид үзэж байна. Энэ нь уг судалгааны ажлын талаарх мэдээлэлгүй байсантай холбоотой байж магадгүй. Урьд өмнө нь хэвлэн нийтлэгдсэн аливаа судалгааны ажлын үр дүн байгаа эсэх болон тэдгээрийг шүүмжлэлтэйгээр харгалзан үзэх ёстой байдаг эрдэм шинжилгээний ажлын стандарт журмыг бүдүүлгээр зөрчсөн энэхүү үйлдлийг Олон улсын Монгол судлаач эрдэмтдийн зүгээс дуугүй харж сууж болохгүй юм.

José Andrés Alonso de la Fuente, Евразийн хэлшинжлэлийн олон улсын сэтгүүлийн найруулагч
Ягеллонский их сургууль, Польш
jose.andres25@gmail.com

Ákos Bertalan Apatóczky, Хятад судлалын тэнхимийн эрхлэгч
Будапештын Károli Gáspár-ын их сургууль, Унгар
aab@azsiaport.hu

Benjamin Brosig, Постдок судлаач, Монгол хэлнүүдийн судлал
Бернийн их сургууль, Швейцар
benjamin.brosig@isw.unibe.ch

Marcel Erdal, Түрк судлалын профессор (тэтгэвртэй)
Франкфуртын их сургууль, Герман
merdal4@gmail.com

Stefan Georg, Алтай хэл соёлын судлалын төлөвлөгөөт бус профессор
Боннын их сургууль, Герман
stefan.georg@bn-online.net

Peter Golden, Түүх, Түрк ба Ойрх Дорнод судлалын профессор
(тэтгэвэрт суусан)
Ратгерсийн их сургууль, Нью -Жерси, АНУ
peterbgolden@gmail.com

Juha Janhunen, Зүүн азийн хэл соёлын профессор (тэтгэврт суусан)
Хельсинкийн их сургууль, Финланд
asiemajeure@yahoo.com

Баярма Хабтагаева, Алтай судлалын хамтарсан профессор
Сегедийн их сургууль, Унгар
baiarma.khabtagaeva@gmail.com

Victor H. Mair, Хятад судлалын профессор
Пенсильванийн их сургууль, АНУ
vmair@upenn.edu

Elisabetta Ragagnin, Түрк Монгол судлалын хамтарсан профессор
Венецийн их сургууль, Итали
betta@vanmeel.org

András Róna-Tas, Академич, Алтай судлалын профессор (тэтгэвэрт суусан)
Сегедийн их сургууль, Унгар
aronatas3@t-online.hu

William Rozycki, Гадаад харилцааны албаны зохицуулагч
Индianагийн их сургуулийн Зүүн Ази Судлалын төв
roz34zz@gmail.com

Pavel Rykin, Ахлах судлаач, Монгол судлал
Санкт-Петербург Хотын ШУА-ын Хэлшинжлэлийн тэнхим
Санкт-Петербург, Орос
pavryk@yandex.ru

Далайн Заяабаатар, Хэл бичгийн ухааны профессор
МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль болон Монгол судлалын
хүрээлэнгийн захирал
zayabaatar@num.edu.mn

Англи хэлээр бичсэн анхны эх нь “International Journal of Eurasian
Linguistics” (JEAL) сэтгүүлийн 3.2 дугаарт хэвлэгдсэн болно.

Ном зүй

- La Vaissière, Étienne de. 2018. The Historical Context to the Khüis Tolgoi Inscription. *Journal Asiatique* 306 (2): 315–319.
- Maue, Dieter & Mehmet Ölmez. 2017. The Khüis Tolgoi Inscription. https://www.academia.edu/40148067/The_Khu_is_Tolgoi_inscription.
- Maue, Dieter. 2018. Signs and Sounds. *Journal Asiatique* 306 (2): 291–301.
- Maue, Dieter. 2019. The Brāhmī Script on the Bugut Stele. *Journal Asiatique* 307 (1): 109–119.
- Өдрийн сонин (Гансаруул, Давхардаваагийн). 2021-3-30. *Хүйс Толгойн бичээсийг тайлж, унисан эрдэмтэн Л. Хурцбаатар: Уг бичээсийг аавынхаа гэрээс, багшийнхаа захиасыг санан санан байж тайлж унисан*. <https://dnn.mn/хүйс-толгойн-бичээсийг-тайлж-унисан-эрдэмтэн-л-хурцбаатар-уг-бичээсийг-аавынхаа-гэрээс-багшийнхаа-захиасыг-санан-санан-байж-тайлж-унисан/>.
- Ölmez, Mehmet. 2018. The Khüis Tolgoi Inscription: On the Discovery, Whereabouts, Condition of the Stones, and an On-the-spot Visit. *Journal Asiatique* 306 (2): 287–289.
- Ölmez, Mehmet. 2019. A Short History of the Bugut Inscription. *Journal Asiatique* 307 (1): 91–96.
- Хурцбаатар, Солонгод Л. 2001. *Zum Činggis-Qayan-Kult*. (Senri Ethnological Papers 11.) Osaka: National Museum of Ethnology.
- Хурцбаатар, Солонгод Л. 2019. 1400 ᠬ ላ እርከን ቀዢ ፕሮቱ ስት/፡ ምስዕስ እናመሰግ ነው(HT1) ነው እናመሰግ፡ “Proto-Mongolian Language 1400 Years Ago. Studies of the Hüüs Tolgoi Inscriptionn [sic!] (HT1)”. Köln: Elias Verlag Imo FiF e.V.
- Хурцбаатар, Солонгод Л. 2020. *1400 жилийн өмнөх өвөг монгол хэл - Хүйс толгойн бичээс (HT1)-ийн судлал*. Köln: Elias Verlag Imo FiF e.V.
- Vovin, Alexander. 2017. Interpretation of the Hüüs Tolgoi Inscription <https://ehess.academia.edu/AlexanderVovin/Draft-Papers>.
- Vovin, Alexander. 2018. An Interpretation of the Khüis Tolgoi Inscription. *Journal Asiatique* 306 (2): 303–313.
- Vovin, Alexander. 2019a. Groping in the Dark: the First Attempt to Interpret the Bugut Brāhmī Inscription. *Journal Asiatique* 307 (1): 121–134.
- Vovin, Alexander. 2019b. A Sketch of the Earliest Mongolic Language: The Brāhmī Bugut and Khüis Tolgoi Inscriptions. *International Journal of Eurasian Linguistics* 1 (1): 162–197.
- Vovin, Alexander. 2021 (forthcoming). The Directionality of the Earliest Turco-Mongolian Language Contacts Revisited: The Data from Mongolic Brāhmī Bugut and Khüis Tolgoi Inscriptions. *Harvard Journal of Turkish Studies*, Festschrift for Marcel Erdal, ed. by Hatice Şirin.